



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар М/182

Улаанбаатар хот

Гамшгийн үед иргэдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дүгээр зүйлийн 13.7, 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.21 дэх заалт, Гамшгаас хамаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.1, 10.3.7, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 23 дугаар зүйлийн 23.1, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3, 7 дугаар зүйлийн 7.5.1, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цартахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.22, 7.1.23 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгийн үед иргэдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах тухай заавар”-ыг нэгдүгээр, Гамшгийн үед үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан нөөцийг тогтмол бүрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн төв, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Энхсайхан/, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буянтогтох/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/, Эрүүл мэндийн хөгжлийн төв/ Б.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

4. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, гамшгийн үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлуудыг оруулан, биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын  
2021 оны 04 сарын 02-ны өдрийн  
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**Гамшгийн үед иргэдэд үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах заавар**

**НЭГ. Үндэслэл.**

1. ДЭМБ, НҮБ-ын Хүн Амын Сангийн мэдээллээр дэлхийн олон оронд гамшиг, онцгой байдлын үед НҮЭМ-ийн иж бүрэн тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх асуудал орхигдож, улмаар хүний нөхөн үржихүйн эрх зөрчигдөж, эх хүүхдийн өвчлөл, эндэгдэл, бэлгийн замаар дамжих халдвар, сэтгэл гутрал, хүчирхийлэл нэмэгддэг нь батлагдсан байна. Дэлхийн улс орнууд газар хөдлөлт, үер, гал түймэр, томоохон үйлдвэрийн осол, олон улсын хөл хориот хүний болон мал амьтны халдварт өвчнүүд зэрэг гамшиг онцгой байдалтай тэмцэх, даван туулах, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр туршлага хуримтлуулж, сургамж авсаар байна.
2. Гамшиг, онцгой байдлын үед НҮЭМ-ийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг багцаар чанартай үзүүлэх нь сум, аймаг, дүүрэг, нийслэл, улсын түвшинд хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэхүү багц нь гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний орхигдсон хэсгийг илрүүлэх, гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг тодорхой болгож, хэрэгжүүлэх, хүмүүнлэгийн тусламжийг нэмэгдүүлэх, гамшигт нэрвэгсэдэд үзүүлэх тусламжийн чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой.
3. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг манай малчдын хувьд хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд зэрэг “аюулт үзэгдэл” нь “гамшгийн эрсдэл” болж, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан өвөрмөц “аюул” буюу ойр ойрхон давтагддаг, удаан үргэлжилдэг гамшиг болсоор байна. Түүнчлэн мал, амьтнаас хүнд халдварлах өвчний дэгдэлт, олныг хамарсан осол гэмтэл, газар хөдлөлт, үер, гал түймэр зэрэг болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал цөөн боловч тохиолдож байна.
4. Гамшиг, онцгой байдлын үед жирэмсэн ба төрсний дараах үеийн хүндрэл үүсэх, төрөх эхийг амрах байр, эмнэлэгт хүргэх, шаардлагатай тусламж, үйлчилгээ, витаминжуулалт, вакцинжуулалт саатах, нярай болон бага насны хүүхдийн зөв зохистой хооллолт алдагдаж, өвчлөл нэмэгдэх, жирэмслэхээс сэргийлэх эм тариа тасалдах, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол, сэтгэл зүйн хямрал болон эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр насныхан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тусламжаас орхигдох, хүчирхийлэлд өртөх нь нэмэгдэх эрсдэлтэй байна.

5. 2019 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн 55 695 (ЭМХТ,2019) тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 712 ногдож байна. Нийт хүндрэлийн дотор жирэмсэн үеийн хүндрэл 43.5 хувь, төрөх үеийн хүндрэл 54.0 хувь, төрсний дараах үеийн хүндрэл 2.5 хувь, жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл 10.8 хувийг тус тус эзэлж байна. Түүнчлэн гэрийн төрөлтийн 229 тохиолдол бүртгэгдснээс 60 нь эмнэлгийн тусламжгүй төржээ. Жирэмслэлт, төрөлтийн хүндрэл илүүтэй тохиолддог 15-19 насны охидын төрөлт тухайн насны 1000 эмэгтэйд харьцуулахад 30.8 байгаа нь 2010 оны үзүүлэлтээс 2.0-оор нэмэгджээ. Сүүлийн 10 жилийн дундажаар нялхсын эндэгдлийн 16.4% нь эмнэлгийн тусламж авалгүй гэртээ эндсэн байна. 2019 онд нялхсын гэрийн эндэгдлийн 176 тохиолдол бүртгэгдэж, нялхсын эндэгдлийн 16.9%-ийг эзэлж байна.
6. Улсын хэмжээнд 2019 онд БЗДХ-ын 17.9 мянган тохиолдол илэрч, сүүлийн 10 жилийн дундажаас 16.4 хувиар өсжээ. Жирэмсэн эмэгтэйчүүдэд тэмбүү илрүүлэх шинжилгээний хувь нэмэгдсэн хэдий ч төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын түвшин (100,000 амьд төрөлтөд ногдох) сүүлийн 10 жилийн байдлаар өсөх хандлагатай байгаа бөгөөд 2019 онд 84 болж, 10 жилийн дундажаас 34- тохиолдлоор нэмэгдэж, өмнөх оныхоос 21-ээр өсчээ. Гамшгийн үед БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, эмчлэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах нь НҮЭМ-ийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна.
7. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, үүний дотор хүчингийн гэмт хэргийн тоо улам нэмэгдэж, олон охид, эмэгтэйчүүдийн сэтгэл зүйн байдал, эрүүл мэнд, амь нас хохирч, хүний эрх ноцтой зөрчигдөж байна. 2019 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 610 бүртгэгдсэн нь 2014 онтой харьцуулахад 1.5 дахин нэмэгдсэн байна. 2019 онд 492 хүн хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон нь 2014 оныхоос 63 хувиар өссөн байна. Энэ хугацаанд хохирогч 7 хүртлэх насны хүүхдийн тоо 3 дахин, 8-17 насны хүүхдийн тоо 2 дахин өссөн нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, улмаар таслан зогсоох, үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.
8. Гэвч гамшгийн үед эх, хүүхдэд үзүүлэх НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн байдал, учруулсан хохирлыг тооцох асуудал, хийсэн судалгаа ховор байна. “Хүүхдийг Ивээх Сан” 2016-2017 оны зудын үед Архангай, Баян-Өлгий аймагт хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан малчдын хүүхдийн ихэнх нь хоол тэжээлийн болон амин дэмийн дутагдлаас шалтгаалсан сульдаатай, өсөлт хөгжилтийн хоцрогдолтой байсан ба ханиадтай, хатгалгаа болж хүндэрсэн хүүхэд цөөнгүй, тэдэнд эмнэлгийн тусламж үзүүлдэг багийн эмч нь даралтын аппарат, чагнуураас өөр багаж хэрэгсэл, анхан шатны тусламжийн иж бүрдэл, эм тариа байхгүй байжээ. Түүнчлэн амьжиргааны наад захын зүйлээр гачигдах, өвдсөн үедээ тусламж, үйлчилгээ авч чадахгүй байх, эдийн засгийн гол эх үүсвэр болсон малаа

алдсанаас сэтгэл зүйн дарамтанд орох, хүчирхийлэлд өртөх зэрэг удаан хугацаанд үргэлжлэх асуудлууд олон байгааг цохон тэмдэглэсэн байна.

9. Монгол Улсын Засгийн газрын “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрт “Гамшиг, онцгой байдлын үед үзүүлэх эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардагдах хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, бичил тэжээл, тээврийн хэрэгсэл, шатахуун, санхүүгийн нөөцийг бодитоор тогтоож, бэлэн байдлыг хангах” заалтыг тусгаж зарим нэг арга хэмжээ авч байгаа боловч энэ үйл ажиллагааг эрчимжүүлж, тодорхой төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

#### **Хоёр. Зорилго.**

Гамшиг, онцгой байдлын үед хүн амд үзүүлэх НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, чанар хүртээмжийг сайжруулснаар эх, хүүхдийн өвчлөл, ноцтой хүндрэлийг бууруулахад энэхүү зааврын зорилго оршино.

**Гамшгийн тодорхойлолт:** Энэхүү зааварт хэрэглэгдэж буй гамшиг, онцгой байдал гэдэгт манай оронд зонхилон тохиолддог зуд, үер усны аюул зэрэг байгалийн онц ноцтой үзэгдлүүдийг хамаатуулан ойлгож болно.

#### **Гурав. Гамшгийн үед НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зарчим**

- Бүх үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх
- Ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш хамруулах
- Хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх
- Олон нийтийг оролцуулсан, тэдний хэрэгцээнд тулгуурласан байх
- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хохирол багатай даван туулахад чиглэгдэх
- Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөөг урьдчилан боловсруулж, шаардагдах зардлыг төсөвт тусган, хэрэгцээтэй хүний нөөц, эм хэрэгслийг захиалан, бэлэн байдлыг хангах

#### **Дөрөв. Гамшиг, онцгой байдлын үед НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт**

##### **4.1. Гамшгийн өмнөх үед гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах**

- 4.1.1. Тохиолдож болзошгүй гамшгуудын эрсдлийг үндэсний хэмжээнд болон бүс нутгаар тооцож, үнэлгээ хийнэ.
- 4.1.2. Гамшгийн үед НҮЭМ -ийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай гэр бүл, хүүхэд эмэгтэйчүүд, өсвөр насныхан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэлийг (байршил, эрүүл мэндийн байдал, НҮЭМ-ийн тусламжийн хэрэгцээ, холбогдох утас, нийгмийн сүлжээний хаяг) нарийвчлан гаргаж сум, дүүргийн онцгой комиссын мэдээллийн санд оруулсан байна.

- 4.1.3. Хүн амын суурьшлийн бүс, отор нүүдлийн байршил, зам, алслагдсан цэгүүдэд хүрэх зай, бүсчлэл, замын тэмдэглэгээг харуулсан газар нутгийн зураглал хийнэ.
- 4.1.4. Отроор өвөлжих, хаваржих малчдад эрүүл мэнд, НҮЭМ-ийн тусламжийг явуулын багаар үзүүлэх төлөвлөгөө, хуваарь гаргаж, бэлэн байдлыг хангана.
- 4.1.5. Гамшиг, онцгой байдлын үед хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлөвлөгөөнд эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ, хүчирхийлэл, гэр бүл төлөвлөлт зэрэг НҮЭМ -ийн асуудлуудыг тусгай бүлэг болгон оруулна.
- 4.1.6. Үндэсний болон нийслэл, аймаг, орон нутгийн хэмжээнд гамшгийн үед үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сурталчилгааны материалыг боловсруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр төлөвлөгөөтэйгөөр сурталчилна.
- 4.1.7. Гамшгийн үед үзүүлэх НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээний иж бүрдлүүдийг тусламжийн төрлөөр нь жагсаалт гарган хэрэгцээтэй эм, хэрэгслийг урьдчилан захиалж, бэлэн байдлыг хангана.
- 4.1.8. Гамшгийн үед НҮЭМ-ийн багц тусламж үзүүлэх гарын авлагыг боловсруулж, үндэсний сургагч багш бэлтгэнэ.
- 4.1.9. Зуданд нэрвэгдэж болох малчин өрхийн хүүхэд, жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд зориулсан аминдэм, эрдсийн бэлдмэл болон жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн хэрэгцээг тооцож, 3-6 сарын нөөцөөр хангасан байна.
- 4.1.10. Зудад нэрвэгдэж болзошгүй бүс нутгийн аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, сум дундын эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь түргэний машиндаа техникийн үзлэг хийлгэн, шаардлагатай сэлбэг хэрэгсэл, бензин шатахуун, яаралтай хэрэглэх эм, бэлдмэл, харилцаа холбооны зардлыг урьдчилан төсөвлөж, бэлэн байдлыг хангасан байна.
- 4.1.11. Сум, тосгоны ЭМТ-ийн эмч, эх баригч, багийн бага эмч нарыг гамшгийн үеийн НҮЭМ-ийн багц тусламж үзүүлэх сургалтанд хамруулна.
- 4.1.12. Гамшгийн үед хамтран ажиллах байгууллагын хүмүүст НҮЭМ –ийн тусламж, үйлчилгээ үзүүлэхийн ач холбогдлын талаар мэдээлэл, ухуулга нөлөөлийн ажил зохион байгуулна.
- 4.1.13. Яаралтай тусламжийн үед ашиглах зөөврийн тоног төхөөрөмжүүд, цахилгааны үүсвэрийг бэлэн байлгана.
- 4.1.14. Төрөлт хүлээн авах нэг удаагийн багцыг нэн шаардлагатай үед хэрэглэхээр бэлдсэн байна.

#### **4.2. Гамшиг, онцгой байдлын үед**

- 4.2.1. Гамшиг, онцгой байдлын үед эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээг эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль, батлагдсан заавар журам, стандарт, удирдамжийн дагуу үйлчлүүлэгчийн харьяалал харгалзахгүй үзүүлнэ.
- 4.2.2. Зуд, ган гачигийн үед отор, нүүдлээр яваа малчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлаар харьяалсан болон байрлаж буй нутгийн засаг дарга, сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч нар харилцан гэрээ байгуулж, хамтран, эргэх холбоотой ажиллана.

- 4.2.3 Хүн амын суурьшлийн бүс, отор нүүдлийн байршил, зам, алслагдсан цэгүүдэд хүрэх зай, бүсчлэл, замын тэмдэглэгээг харуулсан газар нутгийн зураглал дээр жирэмсэн эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлгийн иргэдийн хөдөлгөөнийг тэмдэглэж, мэдээллийг тогтмол шинэчлэнэ.
- 4.2.4 Яаралтай үед эх, хүүхдийг мөрдөгдөж байгаа журмын дагуу шилжүүлэх буюу цахимаар зөвлөгөө авна.
- 4.2.5 Засаг захиргааны шатлал бүрийн онцгой байдлын комиссын гишүүдэд иргэдийн эрүүл мэнд, тусламж, үйлчилгээний байдал, эрсдэл, үр дүнгийн талаарх мэдээллийг шуурхай өгч, мэдээлэл солилцож, хамтарч ажиллана.
- 4.2.6 Гамшигт өртсөн гэр бүл, эмэгтэйчүүдэд сэтгэл зүй, сэтгэл заслын зөвлөгөө, тусламжийг удирдамжийн дагуу үзүүлнэ.
- 4.2.7 Зудад нэрвэгдсэн хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эх, амьжиргааны түвшин доогуур өрх гэр, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд хүмүүнлэгийн тусламжийг нэн тэргүүнд үзүүлж, охид, эмэгтэйчүүдэд ариун цэврийн багцаар хангана.

#### **4.3. Гамшиг, онцгой байдлын дараах үед**

- 4.3.1 Зудын үед малчдын эрүүл мэндэд /НҮЭМ болон эрүүл мэндийн асуудлуудыг оруулсан/ учирсан хохирлын үнэлгээ, дүгнэлт хийнэ. /Сум, аймаг, улсын хэмжээнд/
- 4.3.2. Гамшигийн үед үзүүлсэн НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байдал, гарсан хохирлын дүн мэдээг сум, аймгийн хэмжээнд нэгтгэн эрүүл мэндийн яаманд ирүүлнэ. /Сум, аймаг, улсын хэмжээнд/
- 4.3.3 Сайн туршлага, арга барилыг сурталчилж дэлгэрүүлнэ.
- 4.3.4 Зуд, гамшигт нэрвэгдсэн өрхийн гишүүд ялангуяа хүүхэд, өсвөр үе, жирэмсэн, хөхүүл эхчүүдийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах арга хэмжээ төлөвлөгөөг тэдэнтэй хамтран хийж, хэрэгжүүлнэ.
- 4.3.5 Зуд, гамшигийн үед үзүүлсэн тусламж, үйлчилгээний тайланд үндэслэн болзошгүй гамшигийн үед авах арга хэмжээг зуд, гамшигт нэрвэгдэж байсан малчин өрхийн жирэмсэн эх, нярай хүүхэдтэй эмэгтэй, өсвөр насныхан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулан төлөвлөнө.

#### **Тав. Гамшиг, онцгой байдлын үед НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ үзүүлэх багц**

- 5.1 Эсэн мэнд амаржихуйн тусламж, үйлчилгээ
- 5.2 Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ
- 5.3 Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх тусламж, үйлчилгээ
- 5.4 Хүүхэд, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ
- 5.5 Бэлгийн замаар дамжих халдвар, тэдгээрээс шалтгаалсан өвчлөл, эндэгдлийг бууруулах тусламж, үйлчилгээ

##### **5.1 Эсэн мэнд амаржихуйн тусламж, үйлчилгээ**

Гамшигийн үеийн эсэн мэнд амаржихуйн тусламж, үйлчилгээ нь энэ үед эх, нярайн өвчлөл, ноцтой хүндрэлээс сэргийлэх, эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээг олон нийтийн дэмжлэгтэйгээр цаг алдалгүй, чанартай, хүртээмжтэй үзүүлэх зорилготой.

**5.1.1. Гамшгийн өмнөх үед жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах арга хэмжээ**

- Сум, тосгон, өрхийн ЭМТ-ийн үйлчлэх хүрээний нөхөн үржихүйн насны (15-49 насны) эмэгтэйчүүдийн бүртгэл судалгааг жил бүр шинэчилнэ.
- Жирэмсэн эмэгтэй бүрийн нийгэм-биологийн нөхцөл байдал, эрхтэн тогтолцооны эмгэг, өмнөх жирэмслэлт, төрсний дараах үед гарч байсан хүндрэл зэргийг үнэлэн, эрсдлийг тогтооно.
- Жирэмсэн, нярай хүүхэдтэй эхчүүдийн байршил, төрөх дөхсөн, эрсдэлтэй байдал зэргийг ялгаатайгаар харуулсан зураглалыг сум, тосгоны эмч, эх баригч нар гаргаж, ЭМТ болон сумын Засаг даргын өрөөнд байрлуулж, тухай бүр шинэчилнэ.
- Зудын улмаас эмнэлгийн тусламж авах боломж хязгаарлагдах эрсдэлтэй, өөр аймаг, сумын алслагдсан нутагт отор нүүдэл хийдэг өрхийн төрөх дөхсөн эхийг төв суурин газарт байлгах талаар жирэмсэн эх, түүний ар гэрийнхэнтэй зөвшилцөнө.
- Жирэмсэн болон төрсний дараах үед үүсч болох аюултай шинж тэмдгийн талаарх мэдээллийг эмэгтэй болон түүний ар гэрийнхэнд өгч, эдгээр шинж тэмдгээс нэг нь илрэхэд яаралтай тусламжийг хэнээс хэрхэн авах тухай тайлбарлаж, хандах утасны дугаар, цахим сүлжээний хаягийг өгнө.
- Сумын эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч, багийн бага эмч нарт эх барихын суурь тусламж үзүүлэх ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулна. Үүнд:
  - Эхийн амин үзүүлэлтүүдийг үзэж үнэлэх,
  - Уян зүү тавих
  - Шингэн сэлбэх
  - Хүчилтөрөгч өгөх
  - Манас таталт, урьдал үеийг оношлох, анхны тусламж үзүүлэх
  - Жирэмсний үеийн цус алдалт, авах арга хэмжээ
  - Төрөлт удирдах, эх барих тусламж
  - Төрсний дараах цус алдалтаас урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх
  - Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж
  - Нярайд сэхээн амьдруулах арга хэмжээ авах
  - Жирэмсэн эх, түүний ар гэрийнхэнд зөвлөгөө өгөх арга зүй
- Гамшгийн үед эх барихын яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай иж бүрдлийг бэлтгэж, бэлэн байлгана.  
Эхийг төрүүлэхэд хэрэглэх иж бүрдэл:
  - Мөрдөгдөж байгаа “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”
  - “Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийг удирдах арга зүй” ДЭМБ-ын удирдамж
  - “Эх барихын зонхилон тохиолдох эмгэгүүдийн оношилгоо, эмчилгээний удирдамж” 2020 он
  - Даралтын аппарат 1 ширхэг
  - Пульсоксиметр 1 ширхэг



- Стетоскопи 1 ширхэг
- Тамидины 7.5 хувийн уусмал, 500 мл
- Үзлэгийн цэвэр бээлий 5 хос
- Ариутгасан бээлий 2 хос
- Хулдаасан хормогч
- Эхийн дор дэвсэх, цус нэвтрэхгүй дэвсгэр 2-3 ширхэг
- Умай агшаах эмийн бэлдмэл /окситоцин 5 ш, мезопрстол 5 шахмал/
- Манас таталтаас сэргийлэх, эмчлэх бүрдэл /хүхэр хүчлийн магни 25% 10 мл 6 ампул, диазепам 10 мг 2-3 ампул, даралт бууруулах эмүүд
- Шингэн сэлбэх бүрдэл /Натри хлоридийн 0.9 % 500 мл 5 уут, бүдүүн уян зүү, траниксамийн хүчил 1-2 ампул
- Зүү тариур /3, 5, 10, 20 мл-ийн тариур тус бүр 10 ширхэг, дуслын систем 5 ширхэг/
- Эх барихад хэрэглэх ариутгасан багажийн цомог /хайч 2 ш, хавчаар 2 ш, хүйн хавчаар 2 ш, ариун даавуу 4 ш/
- Төрөх замын гэмтлийг шалгах ариутгасан багажийн цомог /үтрээний толь, өргөгч, цонхот хавчуур 2 ш, мэс заслын хямсаа 1 ш, зүү баригч, викриль утас, зүү 2 ширхэг, ариун даавуу 2 ш/
- Алдсан цусыг хэмжих сав
- Аюулгүй хайрцаг
- Зөөврийн гэрэл, гар чийдэн, батарей, цахилгааны эх үүсвэр

#### **5.1.2 Гамшиг, онцгой байдлын нөхцөлд жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээ**

- Гамшиг, онцгой байдлын үед эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтад гарсан өөрчлөлт, тусламж, үйлчилгээ, мэдээлэл, зөвлөгөөг хаанаас, хэрхэн авах тухай мэдээллийг төв, орон нутгийн телевиз, радио, сум, хороо, дүүргийн цахим хуудас, утасны мессэж, зарлалын самбар, онцгой байдлын комиссын гишүүдээр дамжуулан тухай бүрд нь шуурхай хүргэнэ.
- Үйлчлэх хүрээний жирэмсэн, нярай хүүхэдтэй эхчүүд, жирэмслэх магадлалтай эмэгтэйчүүдийг эх баригч, бага эмч нарт хуваарилан, хүн нэг бүртэй харилцаа холбоо тогтоож, тэдний эрүүл мэндийн байдал, ахуйн хангамж, санал хүсэлтийг хүлээн авч, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна. Эмч, эмнэлгийн ажилтны үйлчлүүлэгчтэй холбогдсон утасны зардлыг төсвөөс гаргана.
- Эрүүл мэндийн төв болон сумын Засаг даргын өрөөнд байрлуулсан газар нутгийн зураглал дээр жирэмсэн, нярай хүүхэдтэй эхчүүдийн байршлыг тухай бүр шинэчилнэ.
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч эсвэл ахлах эмч нь эх баригч, бага эмч нарын цуглуулсан мэдээллийг нэгтгэн, жирэмсэн ба төрсний дараах үеийн хүндрэлийн шинж илэрсэн, төрөх дөхсөн, архаг өвчний сэдрэлттэй жирэмсэн эмэгтэйчүүдэд дуудлагаар тусламж үзүүлэх, сумын ЭМТ-ийн эхийн амрах байранд авчрах, АНЭ, БОЭТ-д хүргэх болон хоол хүнс, түлшний хомсдолын талаар сум, хороо, дүүргийн онцгой байдлын комисст мэдээлж, шаардлагатай тусламж авч, хамтран ажиллана.

- Аливаа гамшгийн үед жирэмсэн эхийг төрөхөөс өмнө эхийн амрах байранд авчирч, төрүүлэх арга хэмжээ авна. Зайлшгүй шаардлага гарсан үед эхийг төрүүлэхэд хэрэглэх иж бүрдлийг ашиглан хамгийн ойрын ЭМТ-д төрүүлнэ.

### **5.1.3 Гамшиг, онцгой байдлын дараах үед авах арга хэмжээ**

- Зудад нэрвэгдсэн өрхийн жирэмсэн эмэгтэй, төрсөн эх, хүүхэд, өсвөр насныханд эмнэлгийн үзлэг хийж, эрүүл мэндийн байдалд үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авна.
- Зудад нэрвэгдсэн болон цартахлын хөл хорионд байсан, короновирусийн халдварт өртсөн эмэгтэйчүүдийн жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл, хүүхэд, өсвөр үеийнхний өсөлт хөгжил, өвчлөл, эндэгдлийн байдал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжид дүн шинжилгээ хийнэ.
- Гарсан дүгнэлтэд үндэслэн болзошгүй гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангах, гамшгийн үед үзүүлэх тусламж, үйлчилгээний төлөвлөгөөг шинэчлэн хийнэ.

## 5.2 Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ

### 5.2.1 Гамшиг, онцгой байдлын өмнөх үед бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах арга хэмжээ

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа дараах зарчмыг баримтлана.
  - Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, үл буруутгах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх
  - Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нэн тэргүүн хамгаалах,
  - Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг шуурхай хангах
  - Нууцлалыг хамгаалах
  - Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх
  - Хүчирхийллийг үл тэвчих
- **Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх:**
  - Сум, хорооны хамтарсан баг нь өөрийн харъяаллын өрх, гэр бүлийн гишүүдээс бэлгийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд, өсвөр насныхан, эмэгтэйчүүдийн бүртгэл, тэдэнтэй холбоо барих утас, хаяг, байршил зэргийг нарийвчлан гаргаж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөнө. Ялангуяа эцэг эх нь мансууруулах бодис, архины хамааралтай, анхаарал халамж тавих хүнгүй, хүчирхийллийн улмаас гэрээсээ зугтаж байсан, сургууль завсардсан, өнчин хагас өнчин, ах дүү хамаатан болон өөр айлд амьдардаг, эцэг, эх нь түр болон урт хугацаагаар өөр газар ажиллаж, амьдардаг хүүхэд, өсвөр үеийнхэн, засаг захиргаа завсардсан, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн өөрчлөлттэй зэрэг эмэгтэйчүүдэд онцгой анхаарна.
  - Бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдлийг үнэлэх, өөрсдийгөө хамгаалах мэдлэг, чадвар олгох сургалтыг хүүхэд, өсвөр насныхан, эмэгтэйчүүдийн дунд зохион байгуулна.
  - Сум, хорооны нутаг дэвсгэрт байгаа ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн явц, чанарт хяналт тавьж, хүүхэд, өсвөр үеийнхэнд хүчирхийллийг үл тэвчих, бэлгийн хүчирхийллийн улмаас хүчирхийлэгч болон хохирогчид учирч болох хор уршгийн талаар олон төрлийн үйл ажиллагааг багш, нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулна.
  - Амьдрахын төлөө, хүүхдээ хамгаалахын тулд биеэ үнэлэх эрсдэлтэй эмэгтэйчүүдийг нийгмийн халамж, хүмүүнлэгийн тусламжид хамруулж, дэмжлэг үзүүлнэ.
  - Хүчингийн гэмт хэрэг үйлдэгдэж болох баар цэнгээний газар, зочид буудал зэрэг газруудын харуул, хамгаалалтын байдалд хяналт тавьж, төв суурин газрын захын хорооллын гудамж талбайг гэрэлтүүлэгтэй болгоно.
  - Өсвөр насны охид, залуу эмэгтэйчүүдийг гадаад дотоодын байгууллагуудад ажилд зуучлах, сургуульд оруулах нэрээр хүчээр бие үнэлүүлэх, хүн худалдаалах, садар самуунд уруу татаж болзошгүй

эрсдлийн талаарх мэдээлэлийг хүлээн авах, эрт илрүүлэх ажлыг зохион байгуулна.

- Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх боломжит тусламж, үйлчилгээний төрөл, хүчирхийлэлд өртсөн, өртөхийг завдсан үед хаана, хэнд, хэрхэн хандах, холбоо барих утсыг мессэж, сум хорооны цахим хуудас, зарлалын самбар, тараах хуудас зэргийг ашиглан мэдээлнэ.
- Архи хэтрүүлэн хэрэглэдэг иргэдийг “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтанд” хамруулна.

• **Онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах:**

- Бэлгийн ба гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, бүртгэх хуудас, тохиолдлыг шилжүүлэх маягт, багийн ажиллах журмыг боловсруулан, багийн гишүүдтэй “нууцын гэрээ” байгуулна.
- Хамтарсан Багийн гишүүдэд холбогдох хууль, удирдамж болон бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах, аюулын зэрэг, нөхцөл байдлыг үнэлэх, хамруулах үйлчилгээний талаар сургалт зохион байгуулна.
- Сум, тосгоны эмч, эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарт гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээнд тулгуурласан, хувь хүний эрхэм чанарыг хүндэтгэсэн, нууцлалыг хадгалсан, чанартай, сэтгэл гаргасан тусламж, үйлчилгээг үзүүлэх хандлага төлөвшүүлэх, тэдэнд зөвлөгөө өгөх, бэлгийн хүчирхийлэлд орсон охид, эмэгтэйчүүдэд үзлэг шинжилгээ хийх, тусламж үзүүлэх ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулна.
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ ганцаарчлан, илэн далангүй ярилцах, тэдний нууцлалыг хадгалахуйц нөхцөл бүрдүүлсэн байна.
- Эмнэлгийн эмч, ажилтнуудтай хийх “Нууцын гэрээний” загварыг хэвлэн бэлтгэнэ.
- Хохирогчийн бүртгэл, эмчилгээ үйлчилгээний тэмдэглэл бүхий карт, өвчний түүх, шилжүүлэх маягт зэрэг холбогдох баримт бичгийг найдвартай, цоожтой шүүгээнд хадгалах нөхцөл бий болгоно.
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч охид, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгдэх иж бүрдлийг бэлтгэж, бэлэн байлгана. Үүнд:

А. Дүүрэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвд байх бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний иж бүрдэл:

- Хүчингийн гэмт хэргийн хохирогчтой ярилцлага хийх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх заавар
- Мөрдөгдөж байгаа “Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, “Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”, “Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар” бүхий хавтас
- Нууцын гэрээний маягт
- Тусламж, үйлчилгээний явцыг тэмдэглэх, мэдэгдэх хуудас, карт
- Тохиолдлыг шилжүүлэх маягт
- Холбогдох байгууллагад шилжүүлэх, зуучлах аргачлал, заавар, хаяг

- Гепатит С ба В, тэмбүү, ДОХ илрүүлэх хурдавчилсан оношлуур хэрэглэх заавар
  - Цусны шинжилгээ авах зүү 2-3 ширхэг
  - БЗДХ-ын шинж тэмдгийн эмчилгээ хийх антибиотууд
  - Жирэмсний сорил 2-3 ширхэг
  - Шээсний шинжилгээ авах сав
  - Яаралтай ууж жирэмслэхээс сэргийлэх эм 2-3 хайрцаг, хэрэглэх заавар
  - Элэгний В вирусийн халдвараас сэргийлэх вакцин (зааврын дагуу хадгална), тариур зүү
  - Ариун цэврийн хэрэгсэл 1 боодол
  - Хохирогчийн биед үүссэн ил шархыг ариутгах бодис, хэсгийн мэдээ алдуулалт хийх тариа, оёдол тавих, цус тогтоох багаж, ариун боолтын материалууд
  - Өсвөр насныхан болон эмэгтэйчүүдэд үзлэг хийхэд тохирсон нэг удаагийн үзлэгийн толь 4-5 ширхэг, бэлгийн замын урагдал гэмтлийг оношлох, оёдол тавих багаж, хэрэгсэл (сургагдсан эмчтэй үед)
  - Аюулгүй хайрцаг
  - Зөөврийн хажуугийн гэрэл, гар чийдэн
- Б. Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, нийслэлийн амаржих газрууд, ЭХЭМҮТ, хувийн хэвшлийн төрөх, эмэгтэйчүүдийн тасагтай нэгдсэн эмнэлгүүдэд байх бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний иж бүрдэл:
- Дээр дурьдсан зүйлүүд бүгд
  - БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээнд цус, наац авах материал
  - Бага насны болон өсвөр насны охидод үзлэг хийх, бэлгийн замын урагдлыг шалгах, оёдол тавихад ашиглах багаж (охидод зориулсан толь, тусгай багаж хэрэгсэл)

### **5.2.2 Онцгой байдлын үед бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ**

- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүд айж, ичих, сэтгэл гутралд орох, айдас түгшүүрт автах, өөрийгөө буруутгах, өөртөө итгэлгүй болох, амиа хорлох оролдлого хийх зэрэг сэтгэл зүйн ноцтой хямралд ордог. Хохирогчийн нууцлал алдагдсан, гэр бүл, олон нийтийг буруутгасан хандлагын үед энэ байдал улам ноцтой болдог. Түүнчлэн хүчингийн улмаас жирэмслэх, бэлгийн замаар дамжих хэд хэдэн төрлийн халдвар авч, хүндрэх, бэлгийн замын урагдлын дараа соривжилт, цооролт үүсэх, биений юмны хямрал, үргүйдэлтэй болох, төрүүлсэн хүүхдээ ялгаварлан гадуурхах зэрэг олон хор уршигтай байдаг. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх НҮЭМ, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ нь дээр дурьдагдсан хор уршиг, сөрөг үр дагаврыг бууруулж, хохирогч эргэж хэвийн байдалд ороход чиглэгдэнэ.
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч амь тэнссэн байдалтай бол яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 7.5.1, 10.2-д зааснаар хохирогчийн оршин суух харьяалал болон хүчирхийлэл дөнгөж сая үйлдэгдсэн эсэх, хохирогч эрүүл мэндийн даатгалтай, иргэний бичиг баримттай эсэхийг үл харгалзан үзүүлнэ.

- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй охид, эмэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ “Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, “Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”, “Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар” зэрэг мөрдөгдөж байгаа журмуудыг баримтална.
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй, өртөх эрсдэлд байгаа охид, эмэгтэйчүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгч бүрийн нэр төр, эрхэм чанарт хүндэтгэлтэй хандана. Тэдэнтэй ярилцах үедээ үйлчлүүлэгчийн сэтгэл зүй, насны онцлогт тохирсон энгийн, ойлгогдох үг хэллэг хэрэглэх, тэдэнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, буруутгасан хандлага, үйлдэл гаргахгүй байх зарчим баримтлана. Хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ тэдний зөвшөөрлийг авч орчуулагч, хэлмэрчийн тусламж авна.
- Хүчиндэх гэмт хэргийг үйлдэгч нь хамаатан садан, ураг төрлийн холбоотой этгээд байх үед хохирогч нь гэмтэл бэртэлээ нуух, санаатайгаар худал мэдээлэл өгөх хандлагатай бөгөөд хүчирхийлэгч эмчийн үзлэгийн үед хамт байж айлган сүрдүүлэх сонирхолтой байдаг. Иймээс хохирогчтой зөвшилцөн, нууц хадгалах нөхцөл бүрдүүлэн, ганцаарчилсан ярилцлага, үзлэг хийнэ. Охидын үзлэгийн үед эх, асран хамгаалагч эмэгтэй, эсвэл нийгмийн ажилтныг байлцуулна.
- Хохирогчоос түүх цуглуулах: ямар хүчирхийлэлд, хаана, хэдий хугацааны өмнө өртсөн болохыг тодруулж, тэмдэглэл хөтлөнө.
- Сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэн, тайвшруулна, шаардлагатай бол мэргэжлийн эмчийн зөвлөгөө авна. Эсвэл сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний клиникийн удирдамжийн дагуу мэргэжлийн эмчид шилжүүлнэ.
- Бие махбодийн, охид, эмэгтэйчүүдийн тусгайлсан үзлэг хийх, охин хальсны бүрэн бүтэн байдлыг дүгнэхдээ хянуур хандах шаардлагатай.
- ХДХВ, тэмбүү, Гепатит С, В илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ хийнэ.
- Жирэмсэн эсэхийг сорилоор тодорхойлно.
- Хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх:
  - Хүчингийн гэмт хэргийн хохирогч болсноос хойшхи 5 хоногийн дотор байгаа бол өсвөр насны охид (биений юм нь ирсэн), нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд яаралтай ууж жирэмслэхээс сэргийлэх эм хэрэглэхийг санал болгоно. Левоноргестролын 1.5 мг -ийн 1 ширхэг шахмалыг 1 удаа хэрэглэх нь илүү зохимжтой.
  - Хүчирхийлэлээс хойш 5-аас дээш хоног өнгөрсөн бол жирэмсний сорил хийж хүчирхийллийн улмаас жирэмсэлсэн тохиолдолд үргэлжлүүлэн тээх, хүүхдээ үрчлүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн, аюулгүй үр хөндүүлэх зэрэг сонголтуудын талаар мэдээлэл өгч, эмэгтэйн шийдвэрийн дагуу үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу шийднэ.
  - Хүчиндүүлэх үед жирэмсэн байсан бол зулбалт, дутуу төрөлт, халдвар зэрэг хүндрэл байгаа эсэхийг тодорхойлж, шаардлагатай бол дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлнэ.
- Бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлж, эмчлэх:

- ХДХВ, Гепатит С, В-ийн хурдавчилсан шинжилгээ эерэг гарсан тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлнэ.
- Гепатит В-ийн шинжилгээ сөрөг гарсан үед вакцин хийлгэхийг санал болгоно.
- Тэмбүүгийн сорил эерэг гарсан болон бусад БЗДХ-ыг шинж тэмдэг, шинжилгээгээр оношилсон үед удирдамжийн дагуу эмчилнэ. Биед үүссэн шарх, гэмтэл бэртлийг илрүүлж, шархыг ариутган, цэгцлэлт хийнэ.
- Бэлгийн замын урагдал, гэмтэл, цооролтыг эх барих, эмэгтэйчүүдийн мэс засал хийх боломжтой эмнэлэгт яаралтай шилжүүлнэ. Бага насны болон өсвөр насны охидын бэлгийн замын урагдлын мэс заслыг унтуулгатай, тохирсон багаж хэрэгсэл ашиглан хийнэ. Шаардлагатай бол ерөнхий мэс заслын болон уролог, протолог эмч нарын зөвлөгөө, тусламж авна.
- Хохирогчид учирсан гэмтэл бэртэл, сэтгэл зүйн байдлын үнэлгээ, НҮЭМ-д учирсан хор уршгийн талаар үнэн зөв тодорхойлох нь хүчингийн гэмт хэрэг үйлдэгч ял завшихгүй байх, хохирогч хэрэгцээт тусламжийг цаг алдахгүй авахад чухал ач холбогдолтой учир эмнэлгийн үйлчилгээ 7 хоногийн 24 цагийн турш бэлэн байх ёстой.
- Нийгэм сэтгэл зүй, нийгмийн халамж, аюулаас хамгаалах, зөрчигдсэн эрхээ хамгаалах, өмгөөлүүлэх тусламж, үйлчилгээнд холбон зуучлана.
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, өсвөр үеийнхний эцэг, эх, асран хамгаалагч нарт сэтгэл заслын тусламж үзүүлнэ.

### **5.2.3 Гамшгийн дараах үед бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ**

- Хүчингийн гэмт хэргийн хохирогчидтой эргэх холбоотой байж, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хуулийн 4.1.7 -д заасны дагуу нөхөн сэргээх тусламж, үйлчилгээг үргэлжүүлнэ. Энэ хугацаанд цочролт үйлдлийн дараах стресс, сэтгэл гутрал, айдас түгшүүр, архи, мансууруулах бодисын хэрэглээ, амиа хорлох талаарх бодол гэх мэт шинж тэмдэгүүдийг заавал үнэлнэ.
- Бэлгийн хүчирхийллийн хохирогчидод үзүүлсэн тусламж, үйлчилгээний дүн мэдээг аймаг, нийслэл, улсын хэмжээнд нарийвчлан гаргаж, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн бүртгэлтэй харьцуулан дүгнэлт хийж, хүчингийн гэмт хэргийг таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

### 5.3. Хүсээгүй жирэмсэлт, үр хөндөлтөөс сэргийлэх тусламж, үйлчилгээ

#### 5.3.1 Гамшгийн өмнөх үед хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ

Гамшиг, онцгой байдлын үед хөл хорионд орох, төв суурин газар очих боломж хязгаарлагдах зэргээс шалтгаалан жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн \ЖСЭХ\ тасралтгүй хэрэгцээг хангах, эмчийн зөвлөгөө тусламж авахад бэрхшээл үүсч улмаар хүсээгүй жирэмслэлт, төрөлт, үр хөндөлт нэмэгдэх эрсдлийг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

- Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвүүд үйлчлэх хүрээний нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэлийг үндэслэн шаардлагатай жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн жил, улирлын бодит хэрэгцээг хавсарсан дааврын эм, дан прогестин агуулсан эм, дааврын тариа, суулгац, яаралтай ууж хэрэглэх эм, эрэгтэй бэлгэвч, ерөндөг гэсэн нэр төрөл тус бүрээр гаргана. Жирэмлэхээс сэргийлэх арга тус бүрийн хэрэгцээг тооцохдоо одоогийн хэрэглэгчдээс үргэлжлүүлэх хүний тоон дээр шинэ хэрэглэгчийн тоог өсвөр насныхан, төрсөн болон зулбалт, үр хөндөлтийн дараах нэмээд, өөр аргад шилжсэн ба жирэмслэхээр төлөвлөсөн эмэгтэйн тоог хасч гаргана. Өсвөр насныхны жирэмслэлт төрөлт нэмэгдэж байгааг харгалзан, өсвөр насны охид, гэрлээгүй залуу эмэгтэйчүүдийн болон отор нүүдэл хийх малчдын хэрэгцээг бодитой тооцоход анхаарвал зохино.
- Мөрдөгдөж байгаа журмын дагуу нийслэл, аймгийн ЭМГ орон нутгийн захиалгыг нэгтгэн, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн хүрээнд чанарын шаардлага хангасан жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулна.
- Өрх, сум, тосгоны ЭМТ нь мөрдөж байгаа журманд зааснаар ЖСЭХ-ийн 3 хүртэлх сарын нөөцтэй байх ёстой боловч малчдын өвөлжилт, хаваржилт хүндрэх зэрэг онцгой байдлын үед татан авалт, түгээлтэнд учирч болох бэрхшээл, зарцуулалтыг харгалзан нөөцийн дээд ба доод түвшинг тодорхойлно. Тухайлбал, хавсарсан дааврын эм, бэлгэвч, дааврын тариа, яаралтай ууж хэрэглэх эмийн 6 хүртэлх сарын нөөцтэй байж болно.
- Одоогоор ЖСЭХ хэрэглэж байгаа, үүнээс ЖСЭХ-ийг үнэгүй олгосон зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хэрэглээний байдал, үргэлжлүүлэн хэрэглэх хэрэгцээ байгаа эсэх, илэрч буй гаж нөлөө зэрэгт үнэлгээ хийж, шаардлагатай бол эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулна.
- Нийслэл, аймгийн ЭМГ, өрх, сум, тосгоны ЭМТ-үүд захиалсан ЖСЭХ-ийг тээвэрлэх, хадгалах, орлого, зарцуулалт, нөөцийг бүртгэх, тайланг гаргаж, нэгтгэхдээ мөрдөгдөж байгаа журмыг чанд баримтлана.
- Зорилтот бүлгийн гэр бүлгийн хос, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх, төрөлт хоорондын зайг зохицуулах, үр хөндөлтийн хор уршиг, жирэмслэхээс сэргийлэх боломжит аргуудын талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулна.
- Үйлчлэх хүрээний нөхөн үржихүйн насныхан ялангуяа өсвөр үеийнхэн, гэр бүлгүй хүмүүс хэрэгцээтэй үедээ гэр бүл төлөвлөлтийн талаарх зөвлөгөө, тусламж, үйлчилгээг хаанаас, хэзээ, хэрхэн авч болох мэдээллийг



- мэдээллийн самбар, сум, өрхийн эмнэлгийн цахим хуудас, гар утас зэрэг төрөл бүрийн арга замаар сурталчилна.
- ЖСЭХ-ийн үйлчилгээ, үр дүн, гарч болох гаж нөлөө, хэрхэн хэрэглэх талаар үйлчлүүлэгчид мэдээлэл, зөвлөгөө өгөх, мэдээлэлд үндэслэсэн сонголт хийлгэх, үйлчлүүлэгчийн эрх, сонголтыг хүндэтгэх, нууцыг хамгаалах, гамшиг, онцгой байдлын үед хэрэглэх нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний иж бүрдлийн талаар өрх, сум, тосгоны эмч, эх баригч, багийн бага эмч нарт чадвар олгох сургалт зохион байгуулна.
  - Үйлчлэх хүрээний өсвөр насныхан, залуучууд хэрэгцээтэй үедээ бэлгэвчийг үнэгүй ба худалдан авах цэгүүдийг байршуулж, бэлгэвчийн гаралтанд хяналт тавьж, тогтмол хангалт сэлбэлт хийнэ. Зочид буудал, баар цэнгээний газрууд, хүнсний худалдааны дэлгүүр, эмийн сангуудын бэлгэвчийн хангалт, худалдааны байдалд хяналт хийнэ.
  - Гамшиг, онцгой байдлын үед хэрэглэх хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх нэн шаардлагатай тусламжийн иж бүрдлийг бэлтгэж, бэлэн байлгана.

А. Өрх, сум, тосгоны ЭМТ-д байх иж бүрдэл:

- “Гэр бүл төлөвлөлт” ДЭМБ-ын Үйлчилгээ үзүүлэгчид зориулсан гарын авлага. Хэрэв байхгүй бол дааврын хавсарсан эм, дан прогестинт эм, тариа, яаралтай ууж хэрэглэх эм, ерөндөг, суулгац, бэлгэвч, мэс заслын аргуудын үйлчилгээ, үр дүн, хэрэглэхэд тохиромжтой болон тохиромжгүй заалтууд, хэрхэн зөв хэрэглэх, гаж нөлөөний үед авах арга хэмжээний талаарх гарын авлага, тараах материал.
- Эрэгтэй бэлгэвч: Үйлчлэх хүрээний хүн амын 20% нь бэлгийн идэвхтэй насны эрэгтэйчүүд, тэдний 20% нь бэлгэвчийг сард 12 удаа хэрэглэнэ гэсэн тооцооллоор хэрэгцээт бэлгэвчийн тоог гаргадаг.
- Эмэгтэй бэлгэвч
- Хавсарсан буюу дан прогестин агуулсан бэлдмэл
- Яаралтай ууж, хэрэглэх эм
- Дааврын тариа, зүү тариур
- Ерөндөг, тавих, авахад хэрэглэгдэх ариун багаж, хэрэгсэл, ариутгалын бодис (сургагдсан эмч, эх баригчтай үед)
- Багийн бага эмчид: бэлгэвч, яаралтай ууж хэрэглэх эм

Б. Дүүргийн ЭМТ, хөөдөөгийн нэгдсэн эмнэлгүүд, сум дундын эмнэлгүүдэд:

- Дээр дурьдсан зүйлүүд бүгд
- Ерөндөг, авах, тавихад хэрэглэх ариун багаж, хэрэгсэл, ариутгалын бодис
- Суулгац, тавих, авахад хэрэглэх ариун багаж, хэрэгсэл, ариутгалын бодис

В. АНЭ, БОЭТ, амаржих газрууд, ЭХЭМҮТ, хувийн хэвшлийн төрөх, эмэгтэйчүүдийн тасагтай нэгдсэн эмнэлгүүдэд:

- Дээр дурьдсан зүйлүүд бүгд
- Эмэгтэйн үр дамжуулах хоолой боох, эрэгтэйн үрийн суваг боох мэс засал хийхэд хэрэглэх багаж, хэрэгсэл, мэдээгүйжүүлэх бодис,

### 5.3.2 Гамшиг, онцгой байдлын үед хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ

- Гамшиг, онцгой байдлын үед хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ нь хувь хүний эрх, сонголтыг хүндэтгэж, нууцыг хадгалсан, хэрэгцээнд тулгуурласан, хүний нас хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ.
- Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах боломж бүрдүүлсэн нөхцөлд ярилцлагыг хийнэ.
- Үйлчлүүлэгчээс хүүхэд төрүүлэх төлөвлөгөөтэй эсэх, одоо жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга хэрэглэдэг эсэх талаар тодруулна.
- Хэрэв, ЖСЭХ хэрэглэдэг бол уг аргыг хир удаан хэрэглэж байгаа, зохимжтой эсэх, ямар нэг асуудал байгаа эсэх, цаашид үргэлжлүүлэх эсвэл жирэмслэх төлөвлөгөөтэй эсэхийг тодруулна. Шаардлагатай зөвлөгөө өгнө. Хавсарсан даавартай эм, бэлгэвчний хангалт хийнэ. Тариа хэрэглэдэг бол товлот хугацааг тохирно, багийн бага эмч хийх боломтой бол тариа тариурыг хэрэглэгчид өгнө. Үр тогтох хугацааг тооцож жирэмслэхээс хамгаалдаг хосод бэлгэвч болон яаралтай ууж хэрэглэх эмийн хангалт хийж, хэрхэн хэрэглэх талаар цогц мэдээлэл өгнө.
- Хэрэв, жирэмслэх төлөвлөгөөгүй боловч аль нэг ЖСЭХ хэрэглэдэггүй үйлчлүүлэгчтэй боломжит аргуудын талаар ярилцана. Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон бол жирэмсэн эсэхийг тодруулж жирэмсний сорил үзнэ. Жирэмсэн бол жирэмсний хяналтанд авч холбогдох зөвлөгөөг өгнө.
- Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсноос хойш эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөөд 5 хоног болоогүй бол Яаралтай ууж хэрэглэх эмийг санал болгож, үр дүн, хэрхэн хэрэглэх, гаж нөлөөний талаарх зөвлөгөөний дараа эмийг өгнө. Онцгой байдал болон гамшгийн үед нэг ширхэгтэй яаралтай ууж жирэмслэхээс хамгаалах эм хэрэглэх нь тохиромжтой. Дараа нь үргэлжлүүлэн хэрэглэх аргуудын талаар мэдээлэл өгч, үйлчлүүлэгчээр сонголт хийлгэнэ. Бэлгэвч, дааврын уух эм сонгосон бол хангалт хийж, хэрхэн хэрэглэх зөвлөгөө өгнө. Тариа, ерөндөг сонгосон бол эмнэлэгт очих хугацааг тохирно. Тухайн эмэгтэйд үйлчилсэн эмч, эх баригч эргэх холбоотой байж, тусламж, үйлчилгээг үр дүнтэй байхыг хариуцна.
- Гамшгийн үед хэрэглэхээр нөөцөлсөн эмийн хүчинтэй хугацааг нарийн хянаж, хугацаа түрүүлж дуусах эм хэрэглэлийг эхлэж хэрэглэх (FIFO) зарчмыг баримтлан хэрэглэж, нөхөн хангалт хийнэ.
- Шаардлагатай бол шатлал ахиулсан үйлчилгээнд шилжүүлнэ.

### **5.3.3 Гамшгийн дараах үед хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх арга хэмжээ**

- Гамшгийн дараа буюу жилийн эцэст үйлчлэх хүрээний хүн ам, үүний дотор зорилтод бүлгийн ЖСЭХ-ийн хэрэглээ, нөөцийн хүртээмжийг арга тус бүрээр тооцож, тайланг журмын дагуу гаргана.
- Гэрлээгүй өсвөр насны охидын жирэмслэлт, нийт үр хөндөлтийн байдалд үнэлгээ хийж, ЖСЭХ-ийн бодит хэрэгцээг дахин тооцож, энэ чиглэлээр хийх мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлж, эмч нарыг зөвлөгөө өгөх аргад дахин сургана.

### **5.4. Гамшгийн үед хүүхэд, нярайд үзүүлэх нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ**

#### **5.4.1. Гамшгийн үед хүүхэд, нярайн өвчлөл, ноцтой хүндрэл гарахаас сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ**

- Өрх, сум, тосгоны ЭМТ үйлчлэх нутаг дэвсгэрт оршин суугаа бүртгэлтэй, шинээр шилжин ирсэн, бүртгэлгүй айл өрхөд байгаа жирэмсэн эх, нярай, 5 хүртлэх насны хүүхдийн судалгааг нарийвчлан гаргаж, ган гачиг, зудад нэрвэгдэх, хөл хорионд орох зэрэг гамшгийн үеийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийнэ.
- Эрсдлийн үнэлгээний байдлыг сум, тосгон, хороо, дүүргийн онцгой байдлын комисст мэдээлж, авах арга хэмжээг гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулна.
- Эхийн амьжиргааны түвшин, боловсрол, эрүүл мэнд, гэр бүлийн байдал зэргийг үнэлэн жирэмсэн болон хүүхэдтэй эхийг нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамруулна
- Нярай болон 5 хүртэлх насны хүүхэд бүрийг мөрдөгдөж байгаа заавар журмын дагуу үзлэгт хамруулан өсөлт хөгжилт, эрүүл мэндийн байдал, дархлаажуулалт, хооллолт, асаргааны байдалд үнэлгээ хийж, авах арга хэмжээний төлөвлөгөө гаргана. Гамшгийн үед хүүхдийн эрүүл мэндийн байдлын талаар ямар хугацаанд хэрхэн холбогдохыг /утас, цахим сүлжээ, оторлох газрын байршил/ тохиролцож, тэмдэглэн мэдээллийн санд оруулна.
- Нярайн асаргаа, хөхөөр зөв хооллох, дархлаажуулалт, аминдэмийн ач холбогдол, нярайд илрэх аюултай шинжүүд, эрүүл хүүхдийн өсөлт хөгжил зэрэг сэдвээр залуу болон шаардлагатай гэр бүлийн хос, эмэгтэйчүүдэд сургалт зохион байгуулж, жирэмсэн болон нярай хүүхэдтэй ээж нарын цахим хуудас нээж, зөв мэдээлэл сурталчилгааг тогтмол хийнэ.
- Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад олон нийтийн оролцоог дэмжиж, энэ чиглэлээр ажилладаг ТТБ-тай хамтран сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалт зохион байгуулна. Туслах дэмжих хүнгүй анх төрж байгаа өсвөр насны болон залуу ээж, хөгжлийн бэрхшээлтэй, эрхтэн тогтолцооны эмгэгтэй эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх сайн дурын идэвхтнүүдийг томилон, холбоо тогтооно.
- Эмч, ажилтнуудад нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж болон хүүхдийн өвчний цогц менежментийн сургалтыг зохион байгуулж эмч бүрийг

- лавлах материалтай болгон, эмч эмнэлгийн ажилтнуудын тусламж үзүүлэх ур чадвар, шаардлагатай эм, хэрэгслийн хангамжийг үнэлэн, дутуу зүйлийг захиалан хангалт хийнэ.
- Өрх, сум, тосгоны ЭМТ-үүд үйлчлэх нутаг дэвсгэрт оршин суугаа жирэмсэн эмэгтэйд жирэмсний хяналтанд орсон үеэс 6 сарын турш, хөхүүл хүүхэдтэй эхэд амаржсаны дараах 2 дахь сараас эхлэн 5 сарын турш хэрэглэх, 06-23 сартай хүүхдэд 6 сар тутамд 4 сарын турш тасралтгүй хэрэглэх Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн захиалга хийж, хэрэглэх зааврын хамт эх, хүүхдэд олгоно.
  - Гамшиг, онцгой байдлын үед жирэмсэн эх бүрийг эмнэлэгт, эмчийн хяналтанд төрүүлж, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж (НЭҮНШТ) үзүүлэх бэлэн байдлыг хангана:
    - Нярайн нас баралтын суурь шалтгааны нэг болох нярайн биеийн дулаан алдалтаас сэргийлэх (төрөх өрөөг 25-28С хэмтэй байлгах, хүүхдийг маш сайн хуурайшуулах, нярайн байдлыг үнэлэх, арьс арьсаар шүргэлцүүлэн эхэд нь тэврүүлэх, хүүхдэд малгай өмсүүлэх)
    - Халдвараас сэргийлэх (эх болон асран хамгаалагч, тусламж үзүүлэгч бүр гарын ариун цэврийг сахих, халдваргүй орчныг бүрдүүлэх)
    - Ангир уургийг эрт амлуулах,
    - Нярайд тусламж үзүүлэх (хүйн лугшилт зогсмогц хүйг хавчиж, таслах, анхны амлуулалтын дараа жинлэх, бодит үзлэг хийх, нүдний арчилгаа, К1 аминдэм тарих, дархлаажуулах)
    - Хөхөөр хооллох, эхийн сүүгээр дагнан хооллохыг дэмжих
  - Нярайн сэхээн амьдруулах ширээнд байх зүйлийг бэлтгэнэ:
    - Дулаацуулах гэрэл, ширээ, дулаан даавуу
    - Амбу, амьсгалын хошуувч
    - Соруулах хэрэгсэл
    - Цаг/таймер
    - Халууны шил
    - Жин
    - Амьсгал тоологч
  - Хугацаанаас өмнө төрсөн нярайд үзүүлэх тусламжийн бэлэн байдлыг хангана:
    - Төрсний дараа дутуу нярайд амьсгалын хямрал үүсэх эрсдлийг бууруулах зорилгоор хугацаанаас өмнө төрж буй эхэд хэрэглэх стероидыг /дексатетазон/ тарихаар бэлтгэх
    - Төрсний дараа хүүхдэд тархины саажилт үүсэхээс сэргийлэхийн тулд төрөлтийн үед магнийн сульфат хэрэглэхээр бэлтгэх
    - Хугацаанаас өмнө ураг орчмын шингэн эрт гарсан үед халдвараас сэргийлэх антибиотикийг бэлтгэх
    - ДЭМБ-ын удирдамжид заасны дагуу тээлтийн нас 37 долоо хоног хүрээгүй, 2000 граммаас бага жинтэй төрсөн, биеийн байдал нь харьцангуй тогтвортой бүх нярайд Имж Эх Асаргааг хийхэд шаардлагатай мэдээлэл, чадвар олгох сургалтыг төрсөн эх, түүний гэр бүлийнхэнд хийхэд бэлтгэх
  - Нярайд эхээс нь аль болох тусгаарлахгүй, хамт байлгах нөхцөл бүрдүүлж, дараах аюултай ерөнхий шинж илэрч байгааг үнэлэн, илэрсэн үед эмчид яаралтай мэдэгдэх талаарх зөвлөмжийг бэлтгэнэ. Үүнд:

- Хөхөө хөхөж чадахгүй буюу сайн хөхөхгүй байх
- Амьсгал олшрох (1 минутанд 60-аас дээш амьсгалах)
- Цээж хүчтэй хонхолзох
- Хөл, гар нь хүйтэн байх
- Орчиндоо харьцаагүй, унтаарсан, ноомой байх
- Халуурах
- Биеийн халуун буурах
- Нярайн арьс, нүд, гарын алга, хөлийн ул шарлах
- Татах
- Хүүхэд, нярайд аюултай шинжүүд илэрсэн үед яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлж, биеийн байдлыг тогтворжуулах эмчилгээг батлагдсан зааврын дагуу хийх, шатлал ахиулсан тусламжид шилжүүлэх, цахим зөвлөгөө авах, аюулгүй тээвэрлэх бэлтгэлийг үнэлэн, шаардлагатай арга хэмжээ авч, бэлэн байдлыг хангасан байна.

#### **5.4.2 Гамшиг, онцгой байдлын нөхцөлд хүүхэд, нярайд үзүүлэх нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ**

- Аливаа гамшгийн үед жирэмсэн эх бүрийг эмнэлэгт төрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна. Малчин эхийг амрах байранд төрөхөөс 7-14 хоногийн өмнө авчрах, мөрдөгдөж буй журмын дагуу АНЭ, БОЭТ-д төрүүлэх эхийг аюулгүй хүргэх, буцааж авчрах унааны асуудлыг урьдчилан шийдвэрлэнэ.
- Төрсөн нярай бүрд нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг зааврын дагуу халдвараас сэргийлэн зөв дэс дарааллаар, цаг хугацаанд нь үзүүлнэ. Өвлийн улирал, цахилгаан тасарсан болон халаалт зогссон үед төрөх өрөөг дулаан байлгах, нярайн сэхээн амьдруулах ширээний дулаацуулах гэрлийг бэлэн байлгахад онцгой анхаарч нөөц цахилгааны эх үүсгэврийг ашиглана. Ангир уургийг эрт амлуулж, хөхөөр хооллох, эхийн сүүгээр дагнан хооллохыг дэмжинэ.
- Шаардлагатай үед нярайн сэхээн амьдруулах арга хэмжээг стандартын дагуу авч эмчлэх, лавлагаа төвөөс зөвлөгөө авах, шилжүүлэх арга хэмжээг цаг алдалгүй авна.
- Жирэмсний 24+0-33+6 долоо хоногтойд 7 хоногийн дотор дутуу төрөх эрсдэлтэй эмэгтэйд Дексатетазоныг 12 мг-аар 12 цагийн зайтай, 24 цагийн дотор 2 удаа булчинд тарина. Сүүлийн тунг хийснээс хойш хамгийн багадаа 48 цагийн дараа төрөлт явагдахад ургийн уушигний хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлсэн байхаар тооцно. Жирэмсний 24-32 долоо хоногтой, төрөлт 24 цагийн дотор эхлэхээр бол ургийн тархины саажилтаас сэргийлж зааврын дагуу хүхэр хүчлийн магниг хэрэглэнэ. Дутуу нярайд тусламж үзүүлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, хүний нөөц дутмаг үед аль болохоор шатлалын тусламжид цаг алдалгүй шилжүүлнэ.
- Нярай болон хүүхдийг журам зааврын дагуу эргэлт хийж, товлотт вакциныг цаг хугацаанд нь хийх үйл ажиллагааг сум орон нутгийн онцгой комисстой хамтран зохион байгуулна.
- Эх, хүүхдэд олгосон олон найрлагат бичил тэжээлийн хэрэглээнд хяналт тавина.

- Нярайг өдөрт 8-12 удаа хөхүүлж, хөхөөр дагнан хооллохыг дэмжиж, амьжиргааны түвшин доогуур өрхийн хөхүүл эхэд хоол хүнс, түлшээр хангах, эмчтэй холбоо барих утас, цахим сүлжээнд холбогдох зэрэгт дэмжлэг үзүүлэх ухуулга нөлөөлийн үйл ажиллагаа зохион байгуулна.
- Гэрийн эргэлт, үзлэг, цахим хуудас, утас ашиглан хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдлыг хянаж, эцэг эхэд нь хүссэн асуудлаар зөвлөгөө өгнө.
- Хүүхэд өвчилсөн үед өвчний хүндийн зэрэг, нэн даруй тусламж үзүүлэх хэрэгцээнд үндэслэн стандартын дагуу эрэмбэлэн, эмчлэх, биеийн байдлыг тогтворжуулах, дээд шатлалын тусламжинд аюулгүй шилжүүлэх арга хэмжээ авна.

#### **5.4.3 Гамшиг, онцгой байдлын дараах үед хүүхэд, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ**

- Гамшиг онцгой байдлын дараа үйлчлэх нутаг дэвсгэрт оршин суугаа өрхийн жирэмсэн эхийн хяналт, шинжилгээ, аминдэм, эрдсийн хэрэглээ, төрсөн нярайн эрүүл мэндийн байдал, жин, хөхөөр хооллосон хугацаа, эхийн сүү татарсан шалтгаан, хүүхдийн өвчлөл, үзүүлсэн тусламж шинжилгээний чанар хүртээмжийн байдалд үнэлгээ дүгнэлт хийнэ.
- Үнэлгээ дүгнэлтийг гамшиг, онцгой байдлын үеийн НҮЭМ-ийн нэн шаардлагатай багц тусламжийн тайланд тусган, сум, хороо, тосгон, дүүрэг, нийслэл, аймаг, улсын онцгой байдлын комисст танилцуулан, дараагийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад ашиглана.
- Гамшигт өртсөн гэр бүлийн хүүхдийн өсөлт хөгжилтийг дэмжих, суурь өвчнийг эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

**5.5. Гамшиг, онцгой байдлын үед бэлгийн замаар дамжих халдвар, тэдгээрээс шалтгаалсан өвчлөл, эндэгдлийг бууруулах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ**

**5.5.1. Гамшгийн өмнөх үед БЗДХ, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах**

Аливаа гамшиг, онцгой байдлын үед БЗДХ, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх, эрт илрүүлгийг зохион байгуулах, эмчлэх боломж хязгаарлагдмал байдгаас хүн амын дунд халдварын тархалт болон тэдгээрээс шалтгаалсан өвчлөл, эндэгдэл ихэнх улс орнуудад нэмэгддэг.

**Халдвар нь** бэлгийн замаар, цусаар, эхээс ураг нярайд ихсээр, төрөх замаар жирэмсэн, төрөх төрсний дараах үед халдвар дамжина. Халдвартай хүний цус цусан бүтээгдэхүүн хийлгэх, зүү тариур ашиглах үед (тэмбүү, гепатит В,С, ХДХВ/ДОХ) цусаар халдвар дамжина.

**Бэлгийн замаар дамжих халдварт өвчинд дараах эмгэгүүд хамаарна:** Тэмбүү, заг хүйтэн, хламиди, трихомониаз, микоплазм, бэлгийн хомхой, хүний хөхөнцөр болон гепатит В,С, ХДХВ/ДОХ-ын вирусийн г.м. халдварууд хамаарна.

**Гамшгийн үед БЗДХ, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх, бууруулахын тулд хурдавчилсан оношилгоо хийж хамшинжээр оношлон эхний шаардлагатай эмчилгээг хийх бэлэн байдлыг хангах хэрэгтэй.**

- Гамшгийн үед хүн амын дунд илрүүлэг хийх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, боломж хязгаарлагдмал байдаг ч хүнд нөхцөл байдалд хүмүүнлэгийн тусламж, сэргийлэх боломжтой арга хэмжээг авах бэлтгэлийг хангаж ажиллана.
- БЗДХ-ын үед үзүүлэх тусламж, үйлчилгээг ЭМС-ын 2017 оны 08 сарын 03-ны А305 тоот журмын дагуу үзүүлнэ.
- Тухайн оршин суугаа орон нутгийн хүн амын дунд БЗДХ, ХДХВ/ДОХ -ын тархалтын түвшинг тогтоох судалгаа хийж эрсдэл бүхий хүмүүсийн судалгааг гаргах, тэднийг эрт илрүүлэг шинжилгээнд хамруулж эмчлэх,
- Өрх сумын эмч эмнэлгийн ажилтанг БЗДХ-аас сэргийлэх дүрэм журам, удирдамжийг таниулж мэдүүлэх, мөрдөж ажиллах талаар мөн БЗДХ-ын шинж тэмдгээр оношлох, эмчлэх, зөвөлгөө өгөх талаар сургалт явуулах, тогтмол хяналт үнэлгээ хийх
- Үйлчлүүлэгчдийн нууцыг хадгалах
- Гамшгийн үед Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн оношлуур, хам шинжээр эмчлэхэд шаардлагатай эм бэлдмэл, бэлгэвч, ариун бээлий, ариутгал, халдваргүйтгэл хийх бодисоор хангах
- Бэлгийн замын халдварт өртөх эрсдэлт бүлгийн хүн амд эрсдэлгүй зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах, нийгмийн ажилтанг татан оролцуулах

- Гамшгийн үед иргэдийг урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сайн дурын зөвлөгөө, шинжилгээ (VCT), эхээс урагт халдвар дамжих эрсдэлийн талаар, ретровирусийн эсрэг эмчилгээ хийлгэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар сурталчлах, тараах материалыг иргэдийн дунд тараах нь чухал юм. Эдгээр үйлчилгээ нь өндөр эрсдэлтэй зан үйл хийдэг бүлгүүдэд илүү чиглэгдэх ёстой.
- Эрүүл мэндийн байгууллагууд, явуулын клиникүүд, хот суурин газрын олон нийтийн төвүүд, томоохон баар, цэнгээний газрууд, хүнсний болон хүнсний бус бараа тараах цэгүүдэд бэлгэвч байрлуулах, байгаа эсэхийг баталгаажуулах.
- Жирэмсэн эмэгтэйд эхээс урагт халдвар дамжих эрсдлийг бууруулахын тулд жирэмслэхээс өмнө болон жирэмсний эхэн үед илрүүлэг шинжилгээнд хамруулж, эмчлэх, бэлгэвч хэрэглэх талаар зөвлөгөө өгөх
- ХДХВ/ДОХ-ын халдвартай эмчилгээ хийлгэдэг хүмүүсийн эмийг тасалдуулахгүй байхаар нөөцийг хангах
- Цус сэлбэх үед ХДХВ, хумхаа, гепатитын вирус, тэмбүү зэрэг халдвар дамжих эрсдэлтэйг анхаарах.
- Цусаар дамжих халдвараас сэргийлэхийн тулд аюулгүй, оновчтой цус сэлбэх бололцоог хангах, стандарт урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг дагаж мөрдөх. Аюулгүй цус сэлбэх талаар баримтлах үндэсний бодлого, үйл ажиллагааг тодорхойлох. Эрүүл мэндийн салбар нь бусад байгууллагуудтай хамтран цусны шинжилгээний багц, аюулгүй цус сэлбэх материалаар хангах, стандарт урьдчилан сэргийлэх арга хэмжээний материалыг тараах хэрэгтэй.
  - Эмнэлгийн байгууллага нь хангамж, зохих мэргэжлийн боловсон хүчин байхгүй тохиолдолд цус сэлбэхийг хориглоно.
  - Шаардлагагүй цус сэлбэхээс зайлсхийж, сэлбэлтийн өөр хэлбэрүүдийг сонгох замаар багасгаж болно.
  - Идэвхтэй цус алдалтаас урьдчилан сэргийлэх, цус алдалтыг зогсоох зорилгоор эм хэрэглэх, стандарт цус орлуулах шингэн хэрэглэх.
  - Аюулгүй цус сэлбэхэд дараахь зүйлс орно:
    - Цусны донорыг сонгох хатуу шалгуурыг боловсруулж, халдварын эрсдэл багатай сайн дурын, төлбөргүй цусны донороос цус авах; ХДХВ-ийн 1, 2, гепатит В, С, болон тэмбүү өвчнийг илрүүлэх оновчтой шинжилгээг ашиглах
    - Цус сэлбэлтийг оновчтой, аюулгүй болгохын тулд ЭМГ-ын ажилтан, эрүүл мэндийн салбар эмнэлгүүдэд аюулгүй, оновчтой цус сэлбэх бололцоогоор хангах
    - Эмнэлгийн ажилтануудад цус сэлбэх арга ажиллагаа, үйлчлүүлэгчийн орны дэргэд цус сэлбэх аюулгүй байдлыг хангах үүднээс үйл ажиллагааны стандартыг дагаж мөрдүүлэх
    - Цусны уут, зүү, тариур зэрэг хог хаягдлыг аюулгүй хаях; цус шинжилдэг, сэлбэлт хийдэг газрууд найдвартай гэрлийн эх үүсвэртэй байх.
- Эмнэлгүүд гамшгийн үед БЗДХ -ын тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангасан төлөвлөгөөтэй байх



**Гамшгийн өмнөх үед халдвараас сэргийлэх стандарт урьдчилан сэргийлэх арга хэмжээг таниулж мөрдүүлэх шаардлагатай.**

- Стандарт урьдчилан сэргийлэлт гэдэг нь үйлчлүүлэгч болон эмнэлгийн ажилтануудад хүрэлцэх замаар болон цусаар, биологийн шингэнээр халдвар дамжих эрсдэлээс сэргийлэх халдвар хяналтын сэргийлэх арга хэмжээ юм.
- Ямар ч нөхцөлд стандарт урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь зайлшгүй шаардлагатай боловч гамшгийн үед дэд бүтэц, хангамж хүрэлцээгүй болж алдагддаг.
- Ажлын хэт ачаалал болон бусад шалтгаанаас болж эрүүл мэндийн ажилтнууд ажлын байранд дүрэм журмыг мөрдөхгүй байх нь үйлчлүүлэгч, ажилчдын аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй юм.
- Бүх хүний цус, биеийн шингэнийг халдвартай гэж үзэн зохих ёсоор сэргийлэх ёстой.
- Энэ нь Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ХДХВ, гепатит В, С болон бусад эмгэг төрүүлэгч бичил биетийн халдвар тархахаас сэргийлдэг.
- Шинээр ажилд орсон өмнө эрүүл мэндийн орчинд ажиллаж үзээгүй туслах ажилтнуудыг сургалтанд хамруулах шаардлагатай.
- Эрүүл мэндийн байгууллагуудын бүх ажилтнуудаас (эмнэлгийн болон туслах ажилтнууд) стандарт урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэгийг үнэлэх ажлын байран дээр сургалт явуулах,
- Стандарт урьдчилан сэргийлэх арга хэмжээний протоколыг эрүүл мэндийн байгууллага бүрт байрлуулж, хянагч нар эдгээрийг дагаж мөрдөж байгааг баталгаажуулах.
- Эрүүл мэндийн ажилтнууд болон туслах ажилтнуудад шаардлагатай тохиолдолд стандарт урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаархи чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах.

**Стандарт урьдчилан сэргийлэх арга хэмжээнд:**

- Гар угаах: үйлчлүүлэгчдэд хүрэхээс өмнө болон дараа гараа савантай усаар угаах
- Гар угаах нөхцөл бололцоог хангах
- Бээлий өмсөх: Цус болон бусад халдвартай байж болзошгүй биеийн шингэнтэй харьцахаар бол ариутгалгүй нэг удаагийн бээлий өмсөх
- Бээлий өмсөхөөс өмнө болон тайлсны дараа гараа угаа.
- Хамгаалах хувцас өмсөх: Цус болон биеийн бусад шингэн цацаж болзошгүй газарт ус нэвтэрдэггүй халат эсвэл хормогч өмсөх.
- Их хэмжээний цусанд өртөж болзошгүй тохиолдолд маск, нүдний шил зүүх

**Хурц иртэй зүйлтэй аюулгүй харьцах:**

- Зүү тариурын хэрэглээг багасгах
- Тарилга бүрт ариутгасан нэг удаагийн тариур, зүү хэрэглэх
- Гэмтлийн эрсдэлийг бууруулах зорилгоор тариа хийх нөхцөлөөр хангах
- Зүүг дахин хэрэглэхгүй байх
- Хэрэглэсэн зүү, хурц үзүүртэй зүйлсийг амархан цоорохгүй шингэн нэвтэрдэггүй аюулгүй хайрцагт хийж хаях. Хурц зүйлийг хэзээ ч ердийн хогийн сав, уутанд хаяж болохгүй.
- Аюулгүй хайрцагаар хангах, хүүхэд хүрэхгүй аюулгүй газар байрлуулах

- Эмнэлгийн бүх хог хаягдлыг тусад нь тусгай талбайд шатаах.
- Устгасны дараа ч аюултай хэвээр байх эд зүйл, тухайлбал хурц үзүүртэй зүйлийг усны эх үүсвэрээс дор хаяж 10 метрийн зайд битүү нүхэнд булна.
- Тарилгад аль болох нэг тунтай шилийг ашиглах, хэрэв олон тунтай тарилга хэрэглэхээр бол бөглөөнд зүү үлдээхээс зайлсхийх, ашигласны дараа олон тунтай шилийг хөргөгчинд хадгалах

#### **Багаж хэрэгслийг халдваргүйжүүлж, ариутгах:**

Ашигласан багаж хэрэгслийг дараах дарааллаар халдваргүйжүүлнэ:

- Гепатит В, С болон ХДХВ-ийн халдвартай багаж хэрэгслэлийг халдваргүйжүүлж аюулгүй болгох.
- Багаж хэрэгслийг ариутгал эсвэл өндөр түвшний ариутгал (HLD) хийхээс өмнө цэвэрлэх
- Ажилбарын үед халдвар дамжихаас сэргийлж багаж хэрэгслийг ариутгах: Уураар автоклаваар ариутгах нь үр дүнтэй (бүх эмгэг төрүүлэгчдийг устгана). Буцалгах эсвэл хлорын уусмалд дэвтээх замаар ариутгахад нян бүрэн устахгүй байж болно.
- Ариутгасан багаж хэрэгслэлийг зөв хадгалах, зөв хэрэглэх

#### **ЭМГ-ын ажилтнууд стандарт сэргийлэлтийн талаар дараах арга хэмжээг зохион байгуулна:**

- Стандартын хэрэгжилтийг хянах, сурталчлах, туслалцаа үзүүлэх арга хэмжээг авах ёстой.
- Анхны тусламж үзүүлэх зөвлөмжийг ажлын байран дээр байрлуулж, өртөлтийн үед эмчилгээнд хэрхэн хамрагдах талаар бүх ажилтанд мэдээлэх.
- Өртөлтөөс сэргийлэх:
  - ЭМА-ны өртөлтийн үед анхны тусламж үзүүлэх арга хэмжээний схемийг байрлуулж, ажилтнуудад мэдээлэх, хаана мэдэгдэх, өртөлтийн дараах сэргийлэлт авахаа мэддэг болгох
  - Өртсөн эрүүл мэндийн ажилтны нууцлалыг хадгалах
  - Өртсөн ЭМА-г Гепатит В, С болон ХДХВ-ийн халдвар дамжих эрсдэлийг үнэлэх: өртөх хэлбэр (арьсан доорх гэмтэл, салст бүрхүүлийн цохилт гэх мэт); өртсөн материалын төрөл (цус, биеийн бусад шингэн гэх мэт); мөн эх үүсвэр өвчтөний ХДХВ-ийн халдвар авах магадлал зэргийг үнэлнэ.
  - Нөлөөлөлд өртсөн ажилтанд өртөлтийн дараах сэргийлэлтэнд хамруулах хэрэгцээ, хэрхэн яаж авах, гаж нөлөө гарсан тохиолдолд юу хийх талаар зөвлөгөө өгөх.
  - Өртсөн ажилчдад ойрын гурван сарын хугацаанд хоёрдогч халдвар дамжихаас урьдчилан сэргийлэх зорилгоор шинжилгээний хариу гартал бэлгэвч хэрэглэхийг зөвлөнө.
  - Өртөлтийн дараах сэргийлэлтэд хамарсан эсэхээс үл хамааран гепатит В,С болон ХДХВ-ийн сайн дурын зөвлөгөө, шинжилгээ өгөх. Өртөлтийн талаархи мэдээлэл бөглүүлнэ.

#### **Өсвөр насныхан:**

Өсвөр насныханд чиглэсэн түгээлтийн цэгүүдэд үнэ төлбөргүй бэлгэвч байрлуулах, эрүүл мэндийн ажилтнууд бэлгийн замын халдварт өвчний шинж тэмдэг илэрч буй

өсвөр насныханд бэлгэвчийн талаар тайлбарлаж зөвлөгөө өгөх. Эрүүл мэндийн байгууллагад ирж үзүүлж буй өсвөр насныханд зориулсан өсвөр насныханд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн байх

### Бэлгэвчийг үнэгүй болгох

Бэлгэвч нь ХДХВ болон бусад бэлгийн замын халдварт өвчин, хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх гол арга юм. Бүх хүн ам бэлгэвчийн талаар мэдлэгтэй байх албагүй ч бэлгэвчийг онцгой байдлын эхний өдрөөс эхлэн хүртээмжтэй байлгах хэрэгтэй бөгөөд өртсөн хүн ам, хүмүүнлэгийн ажилтнууд энэ талаар мэдээлэлтэй байх шаардлагатай. Хангалтыг хянаж тасралтгүй байлгахад анхаарах хэрэгтэй (Бэлгэвчийн хэрэглээг зөв тооцоолох талаар жишээ үзүүлэв)

#### <10,000 -аас цөөн хүн амтай хэсэгт бэлгэвчийн хэрэгцээг тооцох жишээ:

<b>&lt;10,000 цөөн хүн амтай газарт бэлгэвчийн хэрэгцээг тооцох</b>	
Хүн амын дунд бэлгийн идэвхитэй насны эрэгтэй = 20 %	$10,000 \times 0.2 = 2,000$
Бэлгэвч хэрэглэдэг бэлгийн идэвхитэй насны эрэгтэй* = 20 %	$2,000 \times 0.2 = 400$
Эрэгтэйчүүдийн сард хэрэглэсэн бэлгэвч = 12	$400 \times 12 = 4,800$
Алдагдал = 20%	$4,800 \times 0.2 = 960$
Ёард хэрэглэсэн бэлгэвч + алдагдал	$4,800 + 960 = 5,760$
3 сарын хэрэглээг тооцох**	$5,760 \times 3 = 17,280$

\* 20% гэдэг нь өмнөх судалгаанаас авсан нэмэлт мэдээлэл нь бэлгэвчний хэрэглээний түвшин өндөр эсвэл бага байгааг илтгэсэн тохиолдолд өөрчлөх боломжтой ерөнхий тооцоо юм.

\*\* Бэлгэвч ихэвчлэн хайрцгандаа 144 байдаг.

### 5.5.2. Гамшиг, онцгой байдлын үед БЗДХ-ын тусламж, үйлчилгээ үзүүлэх

ЭМС-ын 2017 оны А305 тоот БЗДХ, ХДХВ/ДОХ -ын тусламж, үйлчилгээний журамд өрх сумын түвшинд заг хүйтэн, тэмбүү, трихомниаз, хламидийн халдварыг хурдавчилсан сорил болон хамшинжээр оношилж эхний тусламж үзүүлнэ гэж заасан.

#### **Гамшигийн үед БЗДХ -ыг илрүүлэх эмчлэхэд анхан шатны тусламжийн үзүүлэх зарчим:**

Хамшинжийн оношлогоо эмчилгээний аргын үндсэн онцлогууд:

- Үйлчлүүлэгч аль ч шатны эрүүл мэндийн байгууллагад очсон БЗДХ-ын цогц тусламж, үйлчилгээг анхны ирэлтээр авах боломжтой.
- Өрх, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт лабораторийн шинжилгээ хийх бололцоогүй тохиолдолд БЗДХ-ын тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх боломжтой.

- Тухайн хамшинжийг үүсгэж болох бүх үүсгэгчдийн эсрэг эмчилгээг цаг алдалгүй, өргөн хүрээтэй хийснээр тухайн үйлчлүүлэгчид байж болзошгүй хавсарсан халдварыг бүрэн төгс, эрт эмчилдэг.
- Эрүүл мэндийн боловсрол олгох, хавьтагчийг илрүүлж эмчлэх, бэлгэвч хэрэглэхийг дэмжих зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар БЗДХ-аас сэргийлэх, үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн байгууллагад ханддаг болгох боломжтой.

### **Бэлгийн замаар дамжих халдварын оношилгоо эмчилгээ**

#### **Тэмбүү**

Тэмбүү нь бэлгийн замаар, цусаар дамжин халдварлах ба жирэмсэн үед ихсээр дамжин урагт халдварлаж ураг амьгүй болох төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрөх хүндрэлийг үүсгэнэ. Хурдавчилсан сорил, хам шинжээр илрүүлж оношилно. Тэмбүүгийн халдварын 70% орчим нь шинж тэмдэггүй байдгаас оношлогдох боломжгүй шинж тэмдэг бүдэг, шинэ халдварын үед бэлэг эрхтэн дээр зөөлөн яр шарх гарах цавины булчирхай цочих шинж илэрнэ.

Гамшгийн үед түргэвчилсэн сорилоор тэмбүү эерэг гарсан тохиолдолд эхний эмчилгээг эхлүүлж цаашид БЗДХ-ын эмчтэй хамтран хянаж, оношийг баталгаажуулж эмчилгээний үр дүнг хянана.

#### **Сорил эерэг гарсан үед хийгдэх эмчилгээ:**

Бензатин пенициллин 2,4 сая нэгжээр булчинд 1 удаа тарих **эсвэл** Прокайн пенициллин 1,2 сая нэгжээр өдөр бүр булчинд 1 удаа 10 хоног тарих **эсвэл** Доксациллин 100 мг-аар өдөрт 2 удаа 10-14 хоног уулгана (жирэмсэн үед хэрэглэхгүй). Доксациллины оронд жирэмсэн үед эритромицин 500 мг-аар 4 удаа 30 хоног жирэмсний эхний 3 сард уулгана.

Жирэмсэн эмэгтэйд тэмбүүгийн түргэвчилсэн сорилоор эерэг гарсан, эмчилгээ хийгдээгүй, хяналтанд байгаагүй эсвэл эмчилгээ дутуу хийлгэсэн эхээс төрсөн нярайд төрөлхийн тэмбүүгийн шинж (арьс үрчийсэн, бор саарал өнгөтэй, жин багатай, элэг дэлүү томорсон, арьс гүвдрүүт тууралттай, цэврүүтэлтэй, хамрын шуухинаа илэрсэн, Паррогийн хуурамч саажилт г.м.) илэрсэн бол **нярайд эхний тусламж эмчилгээг хийнэ. Үүнд:**

Кристалл пенициллин 100,000-150,000 нэгж/кг -аар 12 цагийн зайтай 7 хоног, дараа нь 8 цагийн зайтай 10 хоног судсаар тарина **эсвэл** прокайн пенициллин G 50,000 нэгж/кг-аар булчинд 1 удаа тарина

Цаашид мэргэжлийн эмч болон хүүхдийн эмчийн хяналтанд илгээнэ.

#### **Заг хүйтэн**

Заг хүйтэнг гамшгийн үед хам шинжээр оношилж эмчилнэ.

Заг хүйтний үед зовуурь болон эмнэлзүйн шинжээр оношилж эхний эмчилгээг хийнэ

Зовуурьд үтрээнээс ногоон идээрхэг ялгарал ихээр гарна, хэвлийн доод хэсгээр өвдөж болно. Үтрээнд толь тавьж үзэхэд умайн хүзүүний суваг улайж хавагнасан, ногоон идээтэй ялгадас гарна. Зарим үед шээсний сүвний үрэвсэл хавсрах нь түгээмэл тохиолдоно.

### **Хамшинжээр оношилж дараах арга хэмжээг авна.**

Жирэмсэн болон жирэмсэн биш эмэгтэйчүүдэд заг хүйтэн гэж таамаглаж буй эсвэл оношлогдсон бол

- Цефтриаксон 250 мг -аар 1 удаа булчинд Эсвэл Цефитаксим 400 мг-ыг тарина
- Эсвэл Цефтриаксон 250 мг булчинд 1 удаа + азитромицин 1,0 -аар 1 удаа уулгаж хавсарсан эмчилгээ хийнэ.

Заг хүйтний халдвартай эхээс төрсөн нярайд нүдэнд халдвар дамжиж сохрох аюултай.

Халдвар авсан нярайн нүд хавагнаж улайсан нүдээ нээж болохгүй дарахад шар ногоон идээ гарна

Заг хүйтэнтэй эх төрөх гэж байгаа үед **нярайд халдвар дамжихаас сэргийлж** эритромицин 0,5%-ийн тосон түрхлэг эсвэл тетрацикин гидрохлоридын 1%-ийн түрхлэг эсвэл усан суурьтай иод повидон 0,25% -ын уусмалаар угаах эсвэл мөнгөжүүлсэн нитратын 1%-ийн түрхлэг эсвэл хлорамфеникол 1% тосон түрхлэг нүдэнд түрхнэ.

**Хэрэв халдвар авсан бол** нярайд цефтриаксон 25-50 мг/кг (<125 мг) 1 удаа булчинд тарих эсвэл канамицин 25 мг/кг 1 удаа булчинд тарина. Нүдэнд эртиромицины 0,5% -ийн тосон түрхлэгийг шинж тэмдэггүй болтол түрхэнэ.

### **Трихомониаз**

Эмэгтэйд зовуурь илэрсэн тохиолдолд гамшгийн үед хам шинжээр оношилж эмчилнэ.

Трихомониазын үед бэлэг эрхтэн загатнах, толиор шинжлэхэд шар ногоон хөөсөрхөг ялгадас их хэмжээтэй гарна, умайн хүзүү гүзээлзгэний шинж буюу улаан тууралтууд харагдана, умайн хүзүү үтрээний хана улайж хавагнасан цус шүүрэмтгий болсон байдаг.

Хам шинжээр эсвэл нойтон түрхэцийн аргаар оношилж бичил харуураар оношилно.

**Эмчилгээ.** Жирэмсэн биш үед метронидазол 500 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух, эсвэл тинидазол 2,0-аар 1 удаа уух. Жирэмсэн бол эхний 3 сард метронидазол хэрэглэхгүй.

**Гамшгийн үед шээс бэлгийн замын мөөгөнцрийн халдвар хурц хэлбэртэй үед** оношилж эмчлэх шаардлагатай хам шинжээр оношилж эмчилнэ.

Эмнэлзүйн шинжид: бэлэг эрхтэн орчим загатнаж хорсоно, бэлгийн уруул болон үтрээний хана хавагнаж улайсан байна. Үтрээнээс ээдэмцэр төст цайвар наалдамхай ялгарал гарна.

Эмчилгээ: Флюкназол 150 мг 1 удаа уулгах, үтрээнд клотримазолын 1%-ийн тосон түрхлэг 7-14 хоног түрхэх эсвэл 100 мг -ын үтрээний шахмалыг 7 хоног хийх эсвэл 500 мг шахмалыг 1 удаа хийж эмчилнэ.

### ***Нянгийн гаралтай үтрээний үрэвсэл***

Жирэмсэн эмэгтэйчүүдэд нянгийн гаралтай үтрээний үрэвсэл нь зулбах дутуу төрөх, ургийн дотоод халдвар, төрсний дараах умайн салстын үрэвсэл, хорионамнионит үүсгэх эрсдэлтэй тул гамшгийн үед зовуурь илэрсэн эмэгтэйчүүдийг хам шинжээр илрүүлж эмчилнэ.

Гамшгийн үед шинжилгээ оношилгоо хийх боломжгүй үед хам шинжээр оношилно.

**Эмнэлзүйн шинж:** Үтрээнээс эвгүй муудсан загасны үнэртэй төстэй үнэр гарах үтрээний ялгарал нэмэгдэх, наацын шинжилгээнд түлхүүр эс илрэх. Үтрээний ялгарал дээр 10%-ийн КОН дусаахад үнэр илүү мэдрэгдэх шинжүүд илэрнэ.

**Эмчилгээ:** Метронидазол 500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух (жирэмсний эхний 3 сард хэрэглэхгүй), клиндамицин 2%-ийн тосон түрхлэг 7 хоног түрхэнэ. Жирэмсэн үед тинидазол 2,0 өдөрт 1 удаа, 2 хоног **эсвэл** тинидазолыг 1,0 өдөрт 1 удаа 5 хоног уух, клиндамицин лаа 100 мг өдөрт 1 удаа, 3 хоног үтрээнд хий зэрэг сонголтоор эмчилнэ.

### ***Бэлгийн хомхой***

Бэлгийн хомхойн вирусийн 2-р хэв шинжээр үүсгэгддэг. Зовуурь, эмнэлзүйн шинж, PCR -шинжилгээгээр оношилно. Гамшгийн үед бэлгийн хомхойг эмнэлзүйн шинж зовууриар хамшинжийн оношилгоо хийж эмчилнэ. Бэлэг эрхтэн орчим загатнах, хорсож өвдөх, халуурах зэрэг шинж илэрнэ. Үзлэгээр бэлэг эрхтэнд цэврүүт тууралт, шархлаа үүснэ.

**Эмчилгээ:** Жирэмсэн болон жирэмсэн биш эмэгтэйчүүдэд ацикловир 400 мг-аар өдөрт 3 удаа 7-10 хоног уулгана. Нярайд хомхойн халдварын шинжтэй, эсвэл өвчний идэвхитэй үед халдвар дамжих өндөр эрсдэлтэй тул кесар мэс заслаар төрүүлнэ, төрөх замар төрсөн бол нярайд ацикловирийг 20 мг/кг жинд тооцож судсаар 8 цагаар тарьж хэрэглэнэ.

### **Гамшгийн үед эхээс хүүхдэд халдвар дамжихаас сэргийлэх**

- Төрөх тусламжийн үед нэг удаагийн материал ашиглах
- Жирэмсний хяналтанд хамрагдаагүй эсвэл шинжилгээ өгөөгүй, халдварын өндөр эрсдэлтэй тохиолдолд түргэвчилсэн оношлуураар БЗДХ -ыг илрүүлэх шинжилгээ хийнэ

### 5.5.3. Гамшиг, онцгой байдлын дараах үед БЗДХ-ын тусламж, үйлчилгээ

- БЗХ-ыг илрүүлж оношилсон, эмчилсэн тайлан мэдээг гаргаж холбогдох байгууллагууд руу илгээнэ.
- Гамшгийн дараа БЗДХ, ХДХВ/ДОХ-ын халдварыг оношилж хамшинжээр эмчилгээ хийлгэсэн үйлчлүүлэгчдийг харъяа дүүргийн БЗДХ-ын кабинетийн эмчид шилжүүлж хянуулна.
- Жирэмсний хяналт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг БЗДХ, ХДХВ/ДОХ, вируст гепатитийн халдвараас сэргийлэх арга хэмжээтэй уялдуулан зохион байгуулна
- Тухайн орон нутагт түр оршин суугч нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд болон жирэмсэн эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж эрт илрүүлэгт хамруулж хяналтанд авах талаар орон нутгийн засаг захиргааны нэгжтэй хамтран ажиллах

Эрүүл мэндийн сайдын  
 2021 оны 08 сарын 02-ны өдрийн  
 118 дугаар тушаалын 2 дугаар хавсралт


**Гамшгийн үед иргэдийн нөхөн үржихүйн эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлын төлөвлөгөө**

	Үйл ажиллагаа	Хамтран ажиллах байгууллага	Хариуцах газар хэлтэс	Хугацаа	Санхүүгийн эх үүсвэр
1	Иргэдэд гамшгийн үеийн эрсдэлтэй холбоотой мэдээ, мэдээлэл түгээх зорилгоор олон нийтийн мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж, ажиллах	НЭМҮТ	НЭМГ	2021-2022	
2	Төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу нийт иргэд болон зорилтот бүлэгт зориулсан мэдээ, мэдээлэл бэлтгэх, телевиз, радио, сонинд ярилцлага, зөвлөгөө өгөх эмч ажилтныг оролцуулах ажлыг сар бүр зохион байгуулах				
3	Гамшгийн үеийн эрсдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сурталчилгаа хийх чиглэл: - Цар тахлын үеийн хөл хорионы үеийн анхан шатны болон төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын өөрчлөлтийг нийт хүн ам, зорилтот бүлэгт шуурхай хүргэх - Мал, амьтнаас хүнд дамжих				



	<p>халдваруудын эрсдлээс сэргийлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Газар хөдлөлт, үер, усны аюул, эрсдлээс сэргийлэх,</li> <li>- Малчин өрхийн өвөлжилт хаваржилт хүндэрсэн, отор нүүдлийн үед эх хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндэд үүсч болох эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх: (Хоол, хүнс, аминдэм, эрдсийн бэлдмэл, жирэмсний хяналт, эхийн амрах байрны ач холбогдол, жирэмсэн, төрсний дараах үе, нярайд илрэх аюултай шинжүүд, БЗДХ-ын шинж тэмдэг, хор уршиг, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх)</li> <li>- Бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх</li> <li>- Гамшгийн үеийн сэтгэл гутрал, айдас түгшүүрээс сэргийлэх,</li> <li>- Стресс тайлах аргууд</li> </ul>			
4	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, хамтарсан багуудын үр дүнтэй арга барил, үйл ажиллагааг сурталчлах</p>			
5	<p>Зудын үед хүний эрүүл мэндэд учирсан хохирол, эрүүл мэндийн ялангуяа НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд байгаа бэрхшээлийн талаар мэдээлэл</p>			

### Хавсралт 3. Гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий зураглал



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Гамшгаас Хамгаалах Хууль, 2017 он
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль (Шинэчилсэн найруулга), 2016 он
3. 2020-2021 оны зудын гамшгийн хариу арга хэмжээ, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл, 2020 оны 12 дугаар сар
4. Гамшгийн үеийн НҮЭМ-ийн нэн шаардлагатай анхан шатны багц тусламж, үйлчилгээ сургалтын гарын авлага, НҮБ-ын ХАС
5. Онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын гарын авлага, Хүүхдийг Ивээх Сан, 2017 он
6. Хувь хүний нууцын тухай хууль, 1995 он
7. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 2016 он
8. Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийн менежмент, Гарын авлага, 2010
9. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011 он
10. Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 он
11. МУ-ын Шадар сайдын 2017 оны 75 тоот тушаал, "Мэргэжлийн ангийн дүрэм шинэчлэх батлах тухай"
12. МУ-ын Шадар сайдын 2018 оны 125 тоот тушаал, "Гамшгийн эрсдлийн үнэлгээний заавар батлах тухай"
13. ЭМС-ын 2017 оны А\43 тоот тушаал, Ажиллах журам, бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь батлах тухай \Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба ажиллах журам\
14. ЭМС-ын 2017 оны А\305 тоот тушаал, "Журам заавар батлах тухай", \БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, БЗДХ-ын оношлогоо, эмчилгээний заавар\
15. ЭМС-ын 2017 оны А\394 тоот тушаал, Журам батлах тухай" \Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам, Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам\
16. ЭМС-ын 2020 оны А\318 тоот "Журам шинэчлэн батлах тухай" тушаал \Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, Жирэмсэн эмэгтэй үзлэг, шинжилгээний товлол\
17. "Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийг удирдах арга зүй" ДЭМБ-ын удирдамж, 2020 он
18. ЭМС-ын 2020 оны А\364 тоот тушаал, "Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх болон өсвөр насны жирэмсэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай"
19. ЭМС-ын 2020 оны А\490 тоот тушаал, "Аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэх" заавар батлах тухай
20. ЭМС-ын 2019 оны А\293 тоот "Журам заавар батлах тухай" тушаал \Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үлгэрчилсэн журам, Эмнэлгийн яаралтай тусламжид үйлчлүүлэгчийг эрэмблэх заавар, Амилуулах суурь тусламжид нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жишиг жагсаалт\
21. ЭМС-ын 2019 оны А\294 тоот тушаал, "Журам батлах тухай" (Түргэн тусламжийн үйлчилгээг зохион байгуулах үлгэрчилсэн журам)
22. Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай МУ-ын Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол
23. "Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоход эрүүл мэндийн салбарын оролцоо" ЭМЯ, 2020 он
24. Статистикийн тойм: "Гэр бүлийн хүчирхийлэл" УСХ, ЦЕГ, 2020 он
25. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: Хууль эрх зүй, гэмт хэргийн мэдээлэл
26. Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах тухай, ЭМС-ын 2020-ны 25 тоот албан даалгавар
27. Зорилтот бүлгийн иргэдийг короновируст халдвар (ковид 19)-ын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай, ЭМС-ын 2020-ны 29 тоот албан даалгавар

28. Халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах тухай, ЭМС-ын 2020-ны 30-р албан даалгавар
29. ЭМС-ын 2020 оны А/222 тоот “Коронавируст халдварын үед жирэмсэн эмэгтэй, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах журам” батлах тухай тушаал
30. Коронавируст халдвар (ковид 19)-ын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах гарын авлага, ЭМЯ, 2020
31. “Эх барихын зонхилон тохиолдох эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээний удирдамж” ЭМЯ, 2020 он
32. ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд, ЭМС-ын хамтарсан тушаал, 2017 оны А\173, А\251, А\380 тоот тушаал, “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам” батлах тухай
33. ХЗДХ-ийн сайд, ЭМС, Нийгэм хамгааллын сайдын 2017 оны А\80, А\132, А\60 тоот хамтарсан тушаал, “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам” батлах тухай
34. ХЗДХ-ийн сайд, НХ-ын сайд, ЭМС-ын 2017 оны А\63, А\48, А\106 тоот “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журам батлах тухай” хамтарсан тушаал
35. Does index insurance help households recover from disaster? Evidence from IBLI Mongolia (Coping with climate shocks: Results of the Household Panel survey), NSOM, German Institute for economic research
36. Child-Centered Disaster Risk Reduction Toolkit, Plan International, 2010
37. Reproductive Health for Communities in Crisis, UNFPA Emergency Response
38. 2016\2017 Dzud Emergency Response, Mongolia Needs Assessment and Response Plan, People In Needs, Czech Republic, 2017
39. Minimal Initial Service Package, Fact sheet, UNFPA, 2003
40. Minimal Initial Service Package for Reproductive Health in Crisis Situations: A distance Learning Module, UNFPA, 2011
41. Rapid Needs Assessment Report (Ver.2) Mongolian Dzud 2016-2017, Save the Children, 2017
42. Integrating sexual and reproductive health into health emergency and disaster risk management, WHO, 2012
43. Reproductive Health in refugee situations, an inter-agency field manual, UN High Commissioner for Refugees
44. Women’s Refugee Commission, *Field Friendly Guide to Integrate Emergency Obstetric Care in Humanitarian Programs*, RHRC Consortium, 2005. Available from [http://www.rhrc.org/resources/emoc/EmOC\\_ffg.pdf](http://www.rhrc.org/resources/emoc/EmOC_ffg.pdf).
45. Inter-agency Working Group on Reproductive Health in Crises, *Inter-agency Field Manual on Reproductive Health in Humanitarian Settings*, 2010. Available from [http://www.iawg.net/resources/field\\_manual.html](http://www.iawg.net/resources/field_manual.html).
46. Эрүүл мэндийн үзүүлэлт 2019 он, ЭМХТ